# ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ

1995 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр

**Нийтлэг үндэслэл**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь онц байдал зарлах үндэслэл, журам, онц байдлын үед хэрэгжүүлэх онцгой арга хэмжээ, онц байдлыг хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрхийг тогтоож, онц байдал зарласантай холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

...

11 дүгээр зүйл.Бүрэн эрхт төлөөлөгчийн онцгой бүрэн эрх

1.Э-д заасны дагуу томилогдсон Бүрэн эрхт төлөөлөгч дор дурдсан онцгой бүрэн эрх эдэлнэ:

1/э-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

2/нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга Онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхгүй буюу зохих ёсоор биелүүлэхгүй байвал гүйцэтгэлийг шаардаж, тодорхой үүрэг даалгавар өгч, гүйцэтгэлд нь хяналт тавих;

3/онц байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас гаргасан шийдвэр онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаварт харшилж байна гэж үзвэл онц байдлын хугацаанд үйлчлэлийг зогсоох;

4/онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгавар, Засаг даргын захирамжийг биелүүлэхгүй байгаа албан тушаалтныг огцруулах саналыг Засаг даргад тавих.

2.Бүрэн эрхт төлөөлөгчөөс энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасны дагуу өгсөн үүрэг даалгаврыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга заавал биелүүлэх үүрэгтэй.

3.Бүрэн эрхт төлөөлөгчөөс энэ зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасны дагуу тавьсан саналыг Засаг дарга хүлээн авснаас хойш 24 цагийн дотор шийдвэрлэж, хариу мэдэгдэнэ.